



INTERNATIONAL MONETARY FUND



Хэвлэлийн мэдээлэл No. 18/331
ШУУД ТҮГЭЭХ
2018 оны 8-р сарын 7

Олон Улсын Валютын Сан
Вашингтон, К.Т. 20431 АНУ

**Монгол улсад хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн Тав дахь
үнэлгээний талаарх ОУВС-ын ажлын хэсгийн мэдэгдэл.**

Ажлын хэсгийн айлчлалын төгсгөлд гаргаж байгаа хэвлэлийн мэдээлэлд тухайн оронд ажилласан ОУВС-гийн мэргэжилтнүүдийн багийн урьдчилсан дүгнэлтийг танилцуулдаг. Энд илэрхийлсэн байр суурь нь ОУВС-гийн мэргэжилтнүүдийн байр суурь бөгөөд ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн байр суурийн илэрхийлэл байх албагүй юм. Ажлын хэсгийн үнэлгээний урьдчилсан дүгнэлтэнд үндэслэн тайлан боловсруулж, ОУВС-гийн удирдлагаар батлуулсны дараа Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулна.

н.Жэф Готтлийб - ээр ахлуулсан Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн ажлын хэсэг 2018 оны 7-р сарын 25-наас 8-р сарын 6-ны өдрүүдэд Улаанбаатар хотод ажиллаж 2017 оны 5-р сарын 24-ний өдөр батлагдсан гурван жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн тав дахь үнэлгээний яриа хэлэлцээг хийлээ. Уг хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 314.5054 сая ЗТЭ буюу ойролцоогоор 434.3 сая ам.долларын зээл олгохоор анх тохирсон.¹ ([Хэвлэлийн мэдээлэл No. 17/193](#)-ыг харна уу).

Яриа хэлэлцээ нь ОУВС-аас дэмжиж буй хөтөлбөрийн хэрэгжилт, дунд хугацааны төлөв байдал, өрийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн тогтолцоог сэргээх, ядуу иргэдээ хамгаалсан өндөр-чанартай өсөлт гаргахад шаардлагатай бодлогын болон бүтцийн өөрчлөлтүүд дээр төвлөрөн өрнөлөө.

Ажлын хэсгийн айлчлалыг дүгнэж н.Готтлийб дараах мэдэгдлийг хийв:

“Ажлын хэсэг нь Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн тав дахь үнэлгээг бүрэн хийхэд шаардлагатай бодлогуудын талаар үр дүнтэй яриа хэлэлцээг эрх баригчидтай хийлээ. Сүүлийн үеийн макро-эдийн засгийн үзүүлэлтүүд сайн буюу зорилтод түвшиндээ хүрсэн бөгөөд өсөлт эргэн сэргэж байгаа хэдий ч эмзэг байдал бодитой байсаар байна.

¹ Доллараар илэрхийлэх дүнг 2017оны 5-р сарын 24-ний өдрийн ЗТЭ-ийн доллартай харьцах ханшаар тооцох бөгөөд энэ нь 2017 оны 2-р сарын 27-ны өдрийн ЗТЭ-ийн доллартай харьцах ханш буюу 1.35274-өөр тооцсон 425 сая доллар байна

“Ялангуяа санхүүгийн салбарыг сэргээх, бэхжүүлэх бүтцийн өөрчлөлтүүд болон бодлогын хувьд томоохон ахиц гарчээ. Макро-эдийн засгийн бодлогын талаар яриа хэлэлцээ ойрын хугацаанд үргэлжлэх болно.

“Ажлын хэсгийг Монгол улсад байх хугацаанд хамтран ажиллаж, бүтээлч яриа хэлэлцээ өрнүүлэн, найрсаг хүндэтгэлтэй хандсан эрх баригчдад талархал илэрхийлье”